



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

АДААЦАГ СУМЫН ЗАСАГДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.УРАНЦЭЦЭГ ТАНАА

2017.02.02 № 01/07 ДУА-2017/15/КТА-ТШЗ

**Зөрчил арилгуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баярын үйл ажиллагааг санхүүжүүлж, 720,000.00 /Долоон зуун хорин мянга/ төгрөгийг шагналд зарцуулсан байна.

Энэ нь Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 47-р тогтоолын 2.5-д /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын хавсралт “Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3-т /Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх/ заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:



1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, цаашид холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах;

000000013

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Уранцэцэг, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

**ӨГСӨН<sup>1</sup>:**  
ШИНЖЭЭЧ  Ж.УГТАХБАЯР

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ДАРГА  Б.УРАНЦЭЦЭГ  
НЯГТЛАН БОДОГЧ  Б.ЭНХЖАРГАЛ

3АА01019033037  
4815109200

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/